



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Ханан хаданд авиралтын тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ханан хаданд авиралтын тэмцээнийг 2013 оны 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд Төв аймгийн Жаргалант сумын нутаг дахь Дугана хаданд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 678.000 /зургаан зуун далан найман мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төвлөрсөн төсвийн спортын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ня-бо О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг мэргэжилтэн Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны *Наймдугаар* сарын *30*-ны өдрийн
A/44 тушаалын нэгдүгээр хавсралт



Ханан хаданд авиралтын тэмцээн
зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1	Тамирчдын шагнал: 9 x 10.000 төг = 90.000 төг 9 x 8.000 төг = 72.000 төг 9 x 6.000 төг = 54.000 төг	216.000
2	Шүүгчдийн ажлын хөлс: 12 хүн x 1 өдөр x 20.000 төг/	240.000
3	Тээврийн хөлс	60.000
4	Медалийн зардал:	162.000
ДҮН:		678.000 төг

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАСАН:

Б.БАТСАЙХАН

О.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны наймдугаар сарын 30-ны өдрийн
1/41 тушаалын хоёрдугаар хавсралт



Ханан хаданд авиралтын тэмцээний
шүүгчдийн бүрэлдэхүүн

№	Нэрс	Регистрийн дугаар	Зэрэг	Гүйцэтгэх үүрэг
1.	Д.Батжаргал		Улсын шүүгч	Ерөнхий шүүгч
2.	Д.Анхболд		Улсын шүүгч	Нарийн бичиг шүүгч
3.	Б.Ганбаатар		Улсын шүүгч	Цагчин шүүгч
4.	Ц.Цогзолмаа		Улсын шүүгч	Цагчин шүүгч
5.	Л.Болдбаатар		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
6.	Б.Төгсжаргал		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
7.	Г.Бат-Оронго		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
8.	Ч.Ганболд		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
9.	С.Бат-Эрдэнэ		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
10.	Л.Готовдорж		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
11.	Г.Жангар		Улсын шүүгч	Хамгаалагч шүүгч
12.	Д.Баярням		Улсын шүүгч	Хянагч шүүгч

Батлав:

Нийслэлийн Биеийн Тамир Спортын

Газрын дарга:

Ж.Ганболд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны

Ерөнхийлөгч:

Д.Болд

Монголын Хүүхэд Залуучуудын Спорт

Авиралтын Холбооны тэргүүн Д.Батжаргал

2013.08.20.

Улаанбаатар хот

2013 оны хаданд авиралтын

Хотын аврага шалгаруулах тэмцээний заавар

Нэг. Зорилго

Спорт авиралт болон хаданд авиралтыг залуу үеийнхний дунд өргөн сурталчилах, өсвөр насны тамирчдыг олноор төрүүлж гаргах улмаар өндөр ууланд авирагчдыг бэлдэх

Хоёр. Тэмцээн явагдах хугацаа, удирдах байгууллага

Тэмцээнийг 2013 оны 09 дугаар сарын 05-наас 06-нд Төв аймгийн Жаргалант Сумын Нутаг дахь Дугана хаданд зохион байгуулагдана. Хаданд авирагчдын тэмцээнийг Монголын Уулчдын Үндэсний Холбооноос томилогдсон шүүгчид удирдан зохион байгуулна.

Гурав. Тэмцээний журам

Тэмцээнд бага нас охид хөвгүүд (09-14 нас), өсвөр насны эрэгтэй эмэгтэй (15-17 нас), насанд хүрэгчид (18-35 нас) дунд нас (36-45 нас), ахмад нас (46-аас дээш) гэсэн таван насны ангиллаар зохион байгуулагдана.

Жич: Өсвөр насны тамирчид, насанд хүрэгчид төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхтэйгээ ирнэ.

- Тэмцээнийг хурдны, техникийн гэсэн хоёр төрлөөр зохион байгуулж тус бүрийн дүнг гаргана.
- Багийн дүнг багийн бүх гишүүдийн (бага нас, өсвөр нас насанд хүрэгчид гэсэн гурван насны эрэгтэй эмэгтэй тамирчид) тэмцээнд оролцсон нийлбэр дүнгээр бага онооны системээр гаргана.
- Авиралтын маршрут, хурд техникийн замыг техникийн зөвөлгөөн дээр багийн ахлагч нарт танилцуулна.
- Тэмцээнд оролцох тамирчид жигд хувцас лого, холбоо клубын туг хаягтай байна.
- Багууд тамирчдынхаа хэрэглэгдэх материалыг хангасан байна. Үүнд худрага, карбин, корсовк, тальк зэргийг бэлтгэсэн байх
- Дасгалжуулагч тамирчид тэмцээн зохион байгуулж буй байгууллагаас мандат авч оролцоно.

Дөрөв. Шагнал урамшуулал

Тэмцээнд 1, 2, 3-р байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, 1, 2, 3-р байр эзэлсэн багийг алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөлөөр шагнана.

Монголын Хүүхэд Залуучуудын Спорт Авиралтын Холбоо

Утас: 91917937, 88000225